

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, МОНГОЛ УЛСЫН САЙД, ОЛИМП, НИЙТИЙН БИЕЙН ТАМИР,
СПОРТЫН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА, БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 02 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар А/75, А/09, А/23, А/34

Улаанбаатар хот

Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх
арга хэмжээний төлөвлөгөө /2024-2027/ батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, Эрүүл ахуйн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 321 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ (2024-2027)-г нэгдүгээр, Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар, Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газар (Д.Баярболд), Биеийн тамир, спортын улсын хорооны Бодлого төлөвлөлтийн газар (О.Гэрэл), Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын хэлтэс (Т.Барчинлэгсэм)-т тус тус үүрэг болгосугай.

3. Батлагдсан арга хэмжээ, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсвийн төсөлд тусган батлуулах, санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Л.Лувсан), Биеийн тамир, спортын улсын хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Цэрэнболд), Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Б.Батцэцэг), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Батсүх)-т тус тус үүрэг болгосугай.

4. Батлагдсан арга хэмжээ, төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, шаардагдах төсвийг төлөвлөн батлуулж, санхүүжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Батлагдсан арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтэд жил бүр хяналт, тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газар (Д.Баярболд)-д үүрэг даалгасугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЧИНЗОРИГ

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД


Л.ЭНХ-АМГАЛАН

МОНГОЛ УЛСЫН САЙД, ОЛИМП,
НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Х.БУЛГАНТУЯА



ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛЫГ
ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ
(2024-2027)

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын иргэн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй, эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй” гэж, Эрүүл мэндийн тухай хуулийн 43 дугаар зүйлд иргэн өөрийн эрүүл мэндээ хамгаалж, эрүүл мэндийн боловсрол эзэмших, хэвшүүлэх, амьдрал ахуйн таатай нөхцөлийг бүрдүүлэх үүрэг хүлээхээр заасан байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүний өвчлөл, эрсдэлт зан үйл нь хүний амьдарч байгаа хэв маяг, өөрийн зан үйлээс 55% нь, бусад салбарын үйл ажиллагааны үр дагавраас 25% нь, эрүүл мэндийн үйлчилгээнээс 15%, удамшлын хүчин зүйлээс 5% нь хамаардаг болохыг тогтоосон.

Хүн ам, хүүхэд залуучуудын эрүүл зан үйлийн төлөвшилд хувь хүний мэдлэг боловсрол, дадал хэвшлээс гадна хүмүүс хоорондын харилцаа, нийгэм, эдийн засгийн хөгжлийн нөлөө, орчин, бусад салбарт явуулж байгаа бодлогын үр нөлөө, соёл боловсролын түвшин, байгууллага, хамт олны уур амьсгал, оролцооны нөлөөлөл их байдаг нь олон судалгаануудаар нотлогдсон.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030 зорилгыг хангах 2016 оны Шанхайн “Эрүүл мэндийг дэмжих дэлхийн 9 дүгээр бага хурлын Тунхаглал”-д эрүүл мэнд, нийгмийн сайн сайхан байдал нь тогтвортой хөгжлийн тулгуур бөгөөд хүн амд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх нь хүний эрх, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах стратеги болохыг тодорхойлсон.

НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас “Насан туршийн суралцахуй нь Тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх хөдөлгөгч хүч бөгөөд 17 зорилтыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд насан туршийн суралцахуй нь амьдралын бүхий л нөхцөл байдал, цаг үедээ сурч хөгжих үйл явцыг бүхэлд нь хамарсан, суралцах-амьдрах хоёрын нэгдэл бөгөөд хүний сурч, хөгжих бүхий л хэрэгцээг хангах явдал юм” хэмээн тодорхойлж байна.

Нийгмийг илүү хүртээмжтэй, эрх тэгш, амар амгалан болгоход иргэний эрүүл мэндийн боловсрол нэн чухал үүрэгтэй бөгөөд энэ нь зан үйлийн өөрчлөх замаар эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэгдэж, нийгмийн өөрчлөлтийг салбар бүрээр хэрэгжүүлэх нь үр дүнтэй болохыг тодорхойлж, салбар бүрд хүн төвтэй, хүнд ээлтэй, эрүүл мэндийг дэмжсэн, эрүүл мэндийг хамгаалах орчин бүрдүүлэхийг зөвлөсөн байна.

Мөн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод хүн амд эрүүл аж төрөх, амьдралын зөв дадал эзэмшүүлэх ажлыг хүүхэд наснаас нь хэвшүүлэх, зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон,

байгууллагын идэвхтэй оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулах зорилтыг дэвшүүлсэн.

Хүн амд эрүүл мэндийн мэдлэг, дадлыг зан үйлийн өөрчлөлтийн үе шаттай нь уялдуулсан сургалт, сурталчилгаа явуулах, бүх байгууллагын түвшинд эрүүл мэндийг дэмжих орчин бий болгох, нэгдсэн төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт, эрүүл мэндийн тогтолцооны дэмжлэг болон санхүүжилтийн тогтвортой эх үүсвэр үгүйлэгдэж байна.

Иймд хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэхдээ хүний зан үйлийг гэр бүл, найз нөхөд, хамт олон, бусад салбар, байгууллага, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан мэдээлэл, сурталчилгааг тогтмол, системтэйгээр явуулахад чиглэсэн иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх салбар дундын арга хэмжээ (2024-2027)-г боловсрууллаа.

Хоёр. Арга хэмжээний зорилго, зорилт

2.1 Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний зорилго нь нийгмийн салбар, байгууллагын оролцоонд тулгуурлан эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлж, хувь хүн, гэр бүл, хамт олонд эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд оршино.

2.2 Арга хэмжээний хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

2.2.1 иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх салбар дундын зохицуулалтыг бий болгох;

2.2.2 бүх шатны боловсролын байгууллагад эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлж, хүүхэд, залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл зан үйл төлөвшүүлэх;

2.2.3 ажлын байранд эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлж, хөдөлмөрийн насны хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл зан үйл төлөвшүүлэх;

2.2.4 гэр бүл, олон нийт, зорилтот бүлэг, нэг зорилго бүхий сонирхлын бүлгийн хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл зан үйл төлөвшүүлэх;

2.2.5 эрүүл мэндийн салбарт иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх дэмжлэгт орчин бүрдүүлж, манлайллыг сайжруулах.

Гурав. Арга хэмжээг хэрэгжүүлэх зарчим

3.1 Арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1 хүүхдийн болон хүний эрх, тэдний хэрэгцээ, сонирхолд тулгуурлах;

3.1.2 гэр бүл, иргэн, төр, олон нийтийн оролцоо, салбар дундын хамтын ажиллагаа, хамтын хариуцлагад тулгуурлан тэгш байдал, хүртээмжтэй хөгжлийг хангах;

3.1.3 хүн төвтэй, хүний зан үйлийн өөрчлөлтийн онцлог, үе шат, шийдвэр гаргаж оролцох мэдлэг, хандлагад тулгуурлах;

3.1.4 нотолгоонд суурилсан, үр дүнтэй онол арга хэрэгслийг ашиглах.

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа

4.1 Арга хэмжээг 2024-2027 онд хэрэгжүүлнэ.

4.2 Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрүүл мэнд, биеийн тамир, спорт, боловсрол, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

4.3 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх салбар дундын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийг, бүх шатны Засаг даргын дэргэд иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх орон нутгийн зөвлөлийг байгуулж ажиллуулна.

4.4 Зөвлөл нь иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх салбар дундын хамтын ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх, санал, зөвлөмж гаргах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.

4.5 Зөвлөл нь арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтийг жил бүр хэлэлцэж, хэрэгжилтийн явц, үр дүнг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

4.6 Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллага нь бусад төрийн, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэний нийгмийн болон олон улсын байгууллага, иргэдтэй хамтран ажиллаж болно.

Тав. Арга хэмжээний санхүүжилт

5.1 Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

5.1.1 улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2 гадаадын зээл, буцалтгүй тусламж

5.1.3 олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

5.1.4 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж

5.1.5 хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр

Зургаа. Арга хэмжээний үр дүн

6.1 Арга хэмжээг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

6.1.1 иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийг дэмжих салбар дундын зохицуулалт сайжирна.

6.1.2 эрүүл мэндийг дэмжигч боловсролын сургалтын байгууллагын тоо нэмэгдэж, Насан туршийн суралцахуйн төвийг түшиглэн иргэдийн эрүүл мэндийн

боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн үйлчилгээний чиглэл, хүртээмж нэмэгдсэн байна.

6.1.3 ажлын байранд эрүүл мэндийг дэмжих орчин бүрдэж, нийгмийн бүхий л салбар эрүүл мэндийг дэмжигч байгууллагуудтай болсон байна.

6.1.4 гэр бүл, найз нөхөд, үе тэнгийнхэн, сайн дурын бүлгүүдээс зохион байгуулах иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн зөв дадал хэвшил, зан үйлийн өөрчлөлтийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааны тоо нэмэгдсэн байна.

6.1.5 иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх эрүүл мэндийн салбарын тогтолцооны дэмжлэгт орчин бүрдэж, манлайлал сайжирсан байна.

---oOo---

Эрүүл мэндийн сайд, Монгол Улсын сайд, Биеийн тамир, спортын хорооны дарга, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 113/2024/АИЗ дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт

ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /2024-2027/

Зорилго: Нийгмийн салбар, байгууллагын оролцоонд тулгуурлан эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлж, хувь хүн, гэр бүл, хамт олны эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл зан үйл төлөвшүүлэх.													
Зорилт:													
1. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх салбар дундын зохицуулалтыг бий болгох													
2. Бүх шатны боловсролын байгууллагад эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлж, хүүхэд, залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл зан үйл төлөвшүүлэх													
3. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлж, хөдөлмөрийн насны хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл зан үйл төлөвшүүлэх													
4. Гэр бүл, олон нийт, зорилтот бүлэг, нэг зорилго бүхий сонирхлын бүлгийн хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл зан үйл төлөвшүүлэх													
5. Эрүүл мэндийн салбарт иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх дэмжлэгт орчин бүрдүүлж, манлайлыг сайжруулах													
Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая. төг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн сая төг								Хэрэгжүүлэх байгууллага	
				2024		2025		2026		2027		Үндсэн	Хамтрагч
				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв сая төг	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв сая төг	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв сая төг	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв сая төг		
Зорилт 1. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх салбар дундын зохицуулалтыг бий болгох													
1.1 Аймаг, нийслэлийн насан туршийн суралцахуйн төвийг түшиглэн иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, салбар дундын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо бүрдүүлэх	ОУБ Аймаг, нийслэлийн төсөв	30.0	-	Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийг дэмжих орон нутгийн зөвлөл бүх шатны Засаг даргын дэргэд байгуулагдсан байна.	10.0	Бүх шатны Засаг даргын дэргэдэх орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаа тогтворжсон байна.	10.0	Бүх шатны Засаг даргын дэргэдэх орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаа тогтворжсон байна.	5.0	Бүх шатны Засаг даргын дэргэдэх орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаа тогтворжсон байна.	5.0	ЭМЯ	БТСУХ БШУЯ ХНХЯ
1.2 Иргэдэд эрүүл мэндийн боловсрол дээшлүүлэх, эрүүл мэндийг дэмжих санхүүжилтийг зарцуулах, хянах журмыг боловсронгуй болгох, мөрдөх	ОУБ	300.0	Эрүүл мэндийг дэмжих сан	Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журмыг шинэчлэн боловсруулж, батлуулсан байна.	-	Батлагдсан тэргүүлэх чиглэлийн дагуу санхүүжилтийг олгож, төсөл, хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	100.0	Батлагдсан тэргүүлэх чиглэлийн дагуу санхүүжилтийг олгож, төсөл, хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	100.0	Батлагдсан тэргүүлэх чиглэлийн дагуу санхүүжилтийг олгож, төсөл, хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	100.0	ЭМЯ	БТСУХ БШУЯ ХНХЯ
1.3 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл орчин бүрдүүлэх, эрүүл мэндийн нөлөөллийн	ОУБ	20.0	-	Төр, олон нийт, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны сүлжээ	5.0	Хамтын ажиллагааны сүлжээний үйл ажиллагаа тогтмолжсон байна.	5.0	Хамтын ажиллагааны сүлжээний үйл ажиллагаа тогтмолжсон байна.	5.0	Хамтын ажиллагааны сүлжээний үйл ажиллагаа тогтмолжсон байна.	5.0	ЭМЯ	БТСХ БШУЯ ХНХЯ

үнэлгээ хийхэд төр, олон нийт, иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах, хамтын ажиллагааны сүлжээ байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах				байгуулагдсан байна								
1.4 Зохиолон тохиолдох халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн хууль, эрх зүйн орочыг сайжруулах, шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах	ОУБ	100.0	Чихэр лэг бүтээгдэхүүнд онцгой албан татвар ноогдуулах хуулийн төсөл	Хуулийн төслийг батлуулахад чиглэсэн үзүүлэгч нөлөөллийн ажил зохион байгуулсан байна.	50.0	Хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж батлуулахад чиглэсэн үзүүлэгч нөлөөллийн ажил зохион байгуулж, хуулийн төслийг батлуулсан байна.	20.0	Хуулийн хэрэгжилтийг хангах үзүүлэгч нөлөөллийн ажил зохион байгуулсан байна.	10.0	Хуулийн хэрэгжилтийг хангах үзүүлэгч нөлөөллийн ажил зохион байгуулсан байна.	10.0	ЭМЯ БТСУХ БШУЯ ХНХЯ
1.5 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх эрүүл мэндийн мэдээлэл, сургалтын загвар төвийг аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд түшиглэн байгуулах	ОУБ	1,100.0	-	Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх загвар төвийн ажиллах журам, зааврыг боловсруулж, батлуулсан байна.	50.0	3 аймаг, 2 дүүрэгт иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх загвар төвтэй болж, үйл ажиллагаа эхэлсэн байна.	350.0	Шинээр 3 аймаг, 2 дүүрэгт иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх загвар төвтэй болж, үйл ажиллагаа эхэлсэн байна.	350.0	Шинээр 3 аймаг, 2 дүүрэгт иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх загвар төвтэй болж, үйл ажиллагаа эхэлсэн байна.	350.0	ЭМЯ НЭМҮТ БТСУХ БШУЯ ХНХЯ
1.6 Аймаг, дүүргийн Гэр бүл, Хүүхэд, Залуучууд, Хөгжлийн бэрхшээлтэй хүн, Ахмад настны хөгжлийн төв, Насан туршийн суралцахуйн төвийн хүний нөөцийг чадваржуулах	ОУБ, Аймаг, нийслэлийн төсөв	60.0	-	Эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулж, батлуулж, сургалтад ажиллагсдыг хамруулж эхэлсэн байна.	15.0	Сургалтад 60 ажиллагсдыг хамруулсан байна.	15.0	Сургалтад шинээр 60 ажиллагсдыг хамруулсан байна.	15.0	Сургалтад шинээр 60 ажиллагсдыг хамруулсан байна.	15.0	ХНХЯ ЭМЯ НЭМҮТ БЕГ
1.7 Нийгмийн харилцааны хүрээнд хувийн хэвшил, бусад байгууллагаас иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх,	ОУБ	50.0	-	Хувийн хэвшил, бусад байгууллагуудад чиглэсэн үзүүлэгч нөлөөллийн ажил явуулсан байна.	20.0	Хувийн хэвшил, бусад байгууллагуудад чиглэсэн үзүүлэгч нөлөөллийн ажил явуулсан байна.	10.0	Хувийн хэвшил, бусад байгууллагуудад чиглэсэн үзүүлэгч нөлөөллийн ажил явуулсан байна.	10.0	Хувийн хэвшил, бусад байгууллагуудад чиглэсэн үзүүлэгч нөлөөллийн ажил явуулсан байна.	10.0	ЭМЯ НЭМҮТ БТСУХ БШУЯ ХНХЯ

хөрөнгө оруулалт хийх санаачилгыг дэмжих													
1.8 Хүн амын эрүүл мэндийн боловсрол, мэдлэг, хандлага, үр чадварын судалгааг тогтмол хийж, үр дүнг бодлого, төлөвлөлтөд ашиглах	ОУБ	50.0	-	Судалгааг хийж, тайлан, зөвлөмж боловсруулсан байна.	30.0	Судалгааны үр дүн зөвлөмжийг шийдвэр гаргагчдад танилцуулан сурталчилж, төлөвлөгөөнд тусгасан байна	10.0	Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна	10.0	Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна	-	ЭМЯ НЭМҮТ	БТСУХ БШУЯ ХНХЯ
1.9 Биеийн тамир, спортын салбарын "Иргэдийн бие бялдрын түвшин тогтоол сорил"-ыг аймаг, сум, дүүрэг, хороодын эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлэгтэй хамтран зохион байгуулах, иргэдийн мэдээллийг хүний бие бялдрын статик, динамик мэдээллийг харилцан солилцож ашигладаг цахим сүлжээг үүсгэн хэрэгжүүлэх	Улсын төсөв	2000.0	-	Мэдээлэл солилцох эрх зүйн орчныг бүрдүүлж, ТЭЗҮ-ийг боловсруулсан байна	500.0	Мэдээлэл солилцох програм хангамжийг худалдан авах ажиллагааг хэрэгжүүлж, туршиж эхэлсэн байна	1200.0	Цахим сүлжээг үүсгэн салбар хооронд мэдээлэл солилцож эхэлсэн байна	0.0	Мэдээлэл солилцох программ хангамжийн цахим сүлжээний хөгжүүлэлтийг хийсэн байна	300.0	БТСУХ	ЭМЯ БЕГ ХНХЯ
1.10 Халдварт бус өвчний эрсдэл бүхий хүн амыг идэвхтэй хөдөлгөөн, спортоор тогтмол хичээллүүлж, эрүүл мэндэд гарч буй өөрчлөлтийн үр дүнг хүний бие бялдрын статик, динамик үзүүлэлт, асуумжаар өгсөн мэдээлэлд үндэслэн тооцох шинжлэх ухааны үндэслэлтэй цогц судалгааг хэрэгжүүлж, эрсдэлийн үнэлгээг давтамжтай гаргадаг болох	Улсын төсөв	600.0	-	Цогц судалгааг хэрэгжүүлж, эрсдэлийн үнэлгээг давтамжтай гаргадаг болох заавар, журмыг боловсруулж, батлуулсан байна	25.0	Цогц судалгааг хэрэгжүүлж, анхан шатны эрсдэлийн үнэлгээг хийх	200.0	Цогц судалгааг хэрэгжүүлж, дунд шатны эрсдэлийн үнэлгээг хийх	200.0	Цогц судалгааг хэрэгжүүлж, сүүлийн шатны эрсдэлийн үнэлгээг хийх	175.0	БТСУХ	ЭМЯ БЕГ ХНХЯ

1.11 Сум, хороодод зохион байгуулах мэдлэг, чадвар олгох ажлыг спортын үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн байгууллага, эрүүл мэндийн болон спортын төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх	Улсын төсөв	3000.0	-	-	-	Дасгал хөдөлгөөний хөтөлбөр (жор)-ийг хувийн хэвшлийн байгууллага, эрүүл мэндийн болон спортын төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлсэн байна	1000.0	Дасгал хөдөлгөөний хөтөлбөр (жор)-ийг хувийн хэвшлийн байгууллага, эрүүл мэндийн болон спортын төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлсэн байна	1000.0	Дасгал хөдөлгөөний хөтөлбөр (жор)-ийг хувийн хэвшлийн байгууллага, эрүүл мэндийн болон спортын төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлсэн байна	1000.0	БТСУХ	ЭМЯ БЕГ ХНХЯ	
1.12 Халдварт бус өвчний эрсдэл бүхий хүн амд зориулагдсан идэвхтэй хөдөлгөөн, спортоор тогтмол хичээллүүлэх дасгал хөдөлгөөний хөтөлбөр (жор)-ийг насны бүлэг, хүйс, биеийн онцлог тохирсон байдлаар боловсруулж хэрэгжүүлэх	Улсын төсөв	2000.0	-	-	Дасгал хөдөлгөөний хөтөлбөр (жор)-ийг насны бүлэг, хүйс, биеийн онцлогт тохируулан боловсруулж, батлуулсан байна	100.0	Дасгал хөдөлгөөний хөтөлбөр (жор)-ийг хэрэгжүүлж, 100 хүнийг жорын дагуу хичээллүүлсэн байна	600.0	Дасгал хөдөлгөөний хөтөлбөр (жор)-ийг хэрэгжүүлж, шинээр 100 хүнийг жорын дагуу хичээллүүлсэн байна	600.0	Дасгал хөдөлгөөний хөтөлбөр (жор)-ийг хэрэгжүүлж, шинээр 100 хүнийг жорын дагуу хичээллүүлсэн байна	700.0	БТСУХ	ЭМЯ ХНХЯ
1.13 Аймаг, сум, дүүрэг, хороодын эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгийн нөхөн сэргээх, хөдөлгөөн засал, чийрэгжүүлэх үйлчилгээ үзүүлдэг эмнэлгийн ажилтан, биеийн тамирын арга зүйчдийг дасгал хөдөлгөөн, спортын чиглэлээр сургалтад хамруулах	Улсын төсөв	400.0	-	-	Сургалтын хөтөлбөр боловсруулж, батлуулсан, эмнэлгийн ажилтан, биеийн тамирын арга зүйчдийг хамруулж эхэлсэн байна	100.0	Улирал тутам 60 эмнэлгийн ажилтан, биеийн тамирын арга зүйчдийг сургалтад хамруулсан байна	100.0	Улирал тутам шинээр 60 эмнэлгийн ажилтан, биеийн тамирын арга зүйчдийг сургалтад хамруулсан байна	100.0	Улирал тутам шинээр 60 эмнэлгийн ажилтан, биеийн тамирын арга зүйчдийг сургалтад хамруулсан байна	100.0	БТСУХ	ЭМЯ ХНХЯ
Зорилт 2. Бүх шатны боловсролын байгууллагад эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлж, хүүхэд, залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл зан үйл төлөвшүүлэх														
2.1 Эрүүл мэндийг дэмжигч боловсролын сургалтын байгууллага (цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургалтын	ОУБ Хариуцах байгууллагын төсөв	20.0	-	-	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагад тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг боловсруулж, сургалтын хөтөлбөр	5.0	Багц сургалтыг зохион байгуулж, 1000 багш, удирдах ажилтнуудыг хамруулсан байна	5.0	Багц сургалтыг зохион байгуулж, шинээр 1000 багш, удирдах ажилтнуудыг	5.0	Багц сургалтыг зохион байгуулж, шинээр 1000 багш, удирдах ажилтнуудыг хамруулсан байна	5.0	БШУЯ ЭМЯ	БЕГ

байгууллага, политехник коллеж их дээд сургууль)-д тавих шаардлага, шалгуур үзүүлэлт, аргачлал боловсруулж түгээх, багш удирдах ажилтанд сургалт зохион байгуулах				батлуулсан байна									
2.2 Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болох хөдөлгөөнийг бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын дунд өрнүүлэх, үйл ажиллагааг олон нийтэд таниулан мэдээлэх	ОУБ Хариуцах байгууллагын төсөв	20.0	-	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болох хөдөлгөөнийг бүх шатны сургалтын байгууллагуудын дунд өрнүүлж эхэлсэн байна	5.0	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болох хөдөлгөөнийг өрнүүлж, 150 байгууллага эрүүл мэндийг дэмжигч байгууллага болсон байна	5.0	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болох хөдөлгөөнийг өрнүүлж, шинээр 150 байгууллага эрүүл мэндийг дэмжигч байгууллага болсон байна	5.0	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болох хөдөлгөөнийг өрнүүлж, шинээр 150 байгууллага эрүүл мэндийг дэмжигч байгууллага болсон байна	5.0	БЕГ	ЭМЯ
2.3 Эрүүл мэндийг дэмжигч боловсролын болон сургалтын байгууллагын туршлага, арга зүйг түгээн дэлгэрүүлж, тоог нэмэгдүүлэх	ОУБ Хариуцах байгууллагын төсөв	20.0	-	Эрүүл мэндийг дэмжигч сургалтын байгууллагын туршлага, арга зүйг танилцуулах уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, эрүүл мэндийг дэмжигч цэцэрлэг, сургуулийн тоо нэмэгдэж эхэлсэн байна	5.0	Эрүүл мэндийг дэмжигч цэцэрлэг, сургуулийн тоо 40-өөр нэмэгдсэн байна	5.0	Эрүүл мэндийг дэмжигч цэцэрлэг, сургуулийн тоо дахин шинээр 40-өөр нэмэгдсэн байна	5.0	Эрүүл мэндийг дэмжигч цэцэрлэг, сургуулийн тоо дахин шинээр 40-өөр нэмэгдсэн байна	5.0	БЕГ	ЭМЯ
2.4 Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллежийн эрүүл мэндийг хичээл зааж байгаа багш нарт сурагчдын зан үйлийн өөрчлөлтийн үе шатанд тулгуурлан сургалт явуулах арга зүйд сургах.	ОУБ Хариуцах байгууллагын төсөв	100.0	-	"Эрүүл мэнд" хичээлийг зааж байгаа багш нар сургалтад хамрагдаж, гарын авлагатай болсон байна	50.0	Сурагчдын зан үйлийн өөрчлөлтийн үе шатанд тулгуурлан сургалт явуулж, 150 багшийг хамруулсан байна	20.0	Сурагчдын зан үйлийн өөрчлөлтийн үе шатанд тулгуурлан сургалт явуулж, шинээр 150 багшийг хамруулсан байна	10.0	Сурагчдын зан үйлийн өөрчлөлтийн үе шатанд тулгуурлан сургалт явуулж, шинээр 150 багшийг хамруулсан байна	10.0	БЕГ	ЭМЯ

гарын аалага бэлтгэх													
2.5 Эрүүл мэндээ хамгаалах, эрүүл амьдралын дадал хэвшил, зан үйлийг төлөвшүүлэх өсвөрийн сургагч нарыг бэлтгэж, өрөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллежийн түвшинд сайн дурын клуб, дугуйлангийн үйл ажиллагааг зохион байгуулах	ОУБ Хариуцах байгууллагын төсөв	200.0	-	Цэцэрлэг, сургуульд шийдвэр гаргагчид, нийгмийн ажилтан, сэтгэлзүйн, эмч, үе тэнгийн сурагчдаас бүрдсэн баг бий болно.	50.0	Хамтарсан баг ухуулга нөлөөллийн 20 арга хэмжээ зохион байгуулсан байна.	50.0	Хамтарсан баг ухуулга нөлөөллийн шинээр 30 арга хэмжээ зохион байгуулж хэвшсэн байна.	50.0	Хамтарсан баг ухуулга нөлөөллийн шинээр 40 арга хэмжээ зохион байгуулж хэвшсэн байна.	50.0	БЕГ	ЭМЯ
2.6 Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн сургалтын багш бэлтгэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх чиглэлээр хүний нөөцийг нэмэгдүүлэх	ОУБ Хариуцах байгууллагын төсөв	20.0	-	Багш бэлтгэдэг их, дээд сургуулийн багш, эрүүл мэндийн боловсрол хөтөлбөрт элсэн сурагчдын тоо 3-аар нэмэгдсэн байна.	50.0	Багш бэлтгэдэг их, дээд сургуулийн багш, эрүүл мэндийн боловсрол хөтөлбөрт элсэн сурагчдын тоо дахин шинээр 3-аар нэмэгдсэн байна.	50.0	Багш бэлтгэдэг их, дээд сургуулийн багш, эрүүл мэндийн боловсрол хөтөлбөрт элсэн сурагчдын тоо дахин шинээр 3-аар нэмэгдсэн байна.	50.0	Багш бэлтгэдэг их, дээд сургуулийн багш, эрүүл мэндийн боловсрол хөтөлбөрт элсэн сурагчдын тоо дахин шинээр 3-аар нэмэгдсэн байна.	5.0	БШУЯ	ЭМЯ
2.7 Хүүхэд, залуучуудад эрүүл аж төрөх мэдлэг, чадвар, дадлыг төлөвшүүлэхэд чиглэсэн биеийн тамир, спорт, урлаг, соёлын төрөл бүрийн арга хэмжээг боловсролын сургалтын байгууллагууд болон насан туршийн суралцахуйн төвүүдийг түшиглэн зохион байгуулах	ОУБ Аймаг, нийслэлийн төсөв	200.0	-	Эрүүл аж төрөх мэдлэг, чадвар, дадлыг төлөвшүүлэхэд чиглэсэн биеийн тамир, спорт, урлаг, соёлын бүрийн арга хэмжээг зохион байгуулж, 10,000 хүүхэд, залуучуудыг хамруулсан байна.	50.0	Эрүүл аж төрөх мэдлэг, чадвар, дадлыг төлөвшүүлэхэд чиглэсэн биеийн тамир, спорт, урлаг, соёлын бүрийн арга хэмжээг зохион байгуулж, шинээр 10,000 хүүхэд, залуучуудыг хамруулсан байна.	50.0	Эрүүл аж төрөх мэдлэг, чадвар, дадлыг төлөвшүүлэхэд чиглэсэн биеийн тамир, спорт, урлаг, соёлын бүрийн арга хэмжээг зохион байгуулж, шинээр 10,000 хүүхэд, залуучуудыг хамруулсан байна.	50.0	Эрүүл аж төрөх мэдлэг, чадвар, дадлыг төлөвшүүлэхэд чиглэсэн биеийн тамир, спорт, урлаг, соёлын бүрийн арга хэмжээг зохион байгуулж, шинээр 10,000 хүүхэд, залуучуудыг хамруулсан байна.	50.0	БТСУХ БЕГ	ЭМЯ ХНХЯ
2.8 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, насан туршийн суралцахуйн төвийг түшиглэн хүүхэд	ОУБ Аймаг, нийслэлийн төсөв	200.0	-	Хүүхэд залуучуудад нийгэм, сэтгэл зүйн чадвар төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны	50.0	Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна.	50.0	Төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт хийж, тайлан зөвлөмж боловсруулсан байна.	50.0	Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна.	50.0	БЕГ	ЭМЯ БТСУХ ХНХЯ

залуучуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, нийгэм, сэтгэл зүйн чадвар төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг үе шаттайгаар хамтран хэрэгжүүлэх				сурталчилгааны ажлыг зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна				боловсруулсан байна					
2.9 Эрүүл мэндийг дэмжих сургалтын загвар хөтөлбөр боловсруулж, аймаг, нийслэл, дүүргийн насан туршийн суралцахуйн төвийг түшиглэн эцэг эх, сургуулийн эмч, багш, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нар хамтран хэрэгжүүлэх	ОУБ Аймаг, нийслэлийн төсөв	20.0	-	Эрүүл мэндийг дэмжих боловсролын хөтөлбөр боловсруулж, батлуулан, 10,000 эцэг эх, 100 сургуулийн эмч, багш, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нарыг хамруулсан байна	5.0	Эрүүл мэндийг дэмжих боловсролын хөтөлбөр боловсруулж, батлуулан, шинээр 10,000 эцэг эх, 100 сургуулийн эмч, багш, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нарыг хамруулсан байна	5.0	Эрүүл мэндийг дэмжих боловсролын хөтөлбөр боловсруулж, батлуулан, шинээр 10,000 эцэг эх, 100 сургуулийн эмч, багш, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нарыг хамруулсан байна	5.0	Эрүүл мэндийг дэмжих боловсролын хөтөлбөр боловсруулж, батлуулан, шинээр 10,000 эцэг эх, 100 сургуулийн эмч, багш, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нарыг хамруулсан байна	5.0	БЕГ	ЭМЯ ХНХЯ
Зорилт 3. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлж, хөдөлмөрийн насны хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл зан үйл төлөвшүүлэх													
3.1 Ажлын байрны онцлогт тохирсон "Эрүүл мэндийг дэмжих ажлын байр"-ны загвар, шалгуур үзүүлэлт, гарын авлага боловсруулж, эрүүл-аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага шалгаруулах шалгуур үзүүлэлтэд нэмж тусгах	ОУБ Хариуцах байгуул лагын төсөв	20.0	-	Эрүүл мэндийг дэмжих ажлын байрны загвар, шалгуур үзүүлэлт, гарын авлага боловсруулж, эрүүл-аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага шалгаруулах шалгуур үзүүлэлтэд нэмж тусгасан байна	5.0	Нэмж тусгасан шалгуур үзүүлэлтийн дагуу 20 байгууллага эрүүл-аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага болсон байна	5.0	Нэмж тусгасан шалгуур үзүүлэлтийн дагуу шинээр 20 байгууллага эрүүл-аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага болсон байна	5.0	Нэмж тусгасан шалгуур үзүүлэлтийн дагуу шинээр 20 байгууллага эрүүл-аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага болсон байна	5.0	ХНХЯ	ЭМЯ БТСУХ БШУЯ
3.2 Эрүүл мэндийг дэмжих байгууллага, ажлын байр бий болгох хөдөлгөөнийг нэгдсэн зохион байгуулалтаар хангах асуудлыг Хөдөлмөрийн аюулгүй байдлын үндэсний хорооны чиг үүрэгт нэмж тусган хэрэгжүүлэх	ОУБ Хариуцах байгуулла- гын төсөв	20.0	-	Нэгдсэн зохион байгуулалтаар хангах, зөвлөлдөх салбар дундын хамтран ажиллах механизмыг бий болгох журам, заавар, төлөвлөгөө боловсруулсан байна	5.0	Нэгдсэн зохион байгуулал таар хангах, зөвлөлдөх салбар дундын хамтран ажиллах механизм бүрдсэн байна.	5.0	-	-	-	-	ХНХЯ	ЭМЯ БТСУХ

